

ӨДӨР ТУТМЫН СОНИНЫ ЯРИЛЦЛАГАД ХИЙСЭН
ЗАРИМ АЖИГЛАЛТ, ДҮГНЭЛТ

С. Бэрцэцэг*

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант

Түлхүүр үг: бичлэгийн төрөл зүйл, сонины ярилцлага, сэтгүүлчийн ур чадвар, цаг үе, аман яриа

Хүн төрөлхтний өөр хоорондоо мэдээлэл солилцох анхны хэлбэр нь дохио зангаа байжээ. Дараа нь үйл хөдлөлөөрөө бус үг хэлээрээ харилцдаг болсон билээ. Чухам энэ л үеэс хүмүүс хоорондын харилцаа амар хялбар болж, урьд өмнө ойлголцоход бэрхшээлтэй байсан дотоод сэтгэлийн хөдлөлөө ил гарган илэрхийлэхэд түвэггүй болжээ. Харин бичиг үсэг үүссэнээр тэрхүү аман яриаг тэмдэглэн үлдээж, олон нийтэд дамжуулах боломж бүрдсэн байна. Энэ л үеэс харилцан ярианы тэмдэглэл буюу ярилцлага үүсчээ

Ярилцлага буюу интервью хэмээх үг франц хэлний interview - “өөр хоорондоо зочлох” гэсэн үгнээс гаралтай. XVIII зууны 30-аад оны үед Английн хоёр сэтгүүлч Лондон хотын амьдралын талаар оршин суугчдын санал сэтгэгдлийг сонсож, асуулт тавьж хариулт авснаа эвлүүлж сонинд нийтэлснийг анх interview буюу ярилцлага гэж нэрлэсэн түүхтэй юм¹.

1609 онд Германд, 1622 онд Англид, 1631 онд Францад анхны хэвлэмэл сонинууд үүсэхэд тэдгээрийн хуудаснаа ярилцлага маягийн зүйлс хэвлэгдэж эхэлсэн байна. Үндсэндээ ярилцлага бол ХҮII зууны эхний хагаст Англид бий болсон гэж үздэг. ХҮII зууны сүүл ХҮIII зууны эхээр Европын бүх оронд ярилцлага баттай байр сууриа эзлэх болжээ. Сонины ярилцлага хэмээх сэтгүүл зүйн бичлэгийн зүйл эрт дээр үед үүсч, Монголын хэвлэлд ч мөн анхдагч төрлийн нэг болон хөгжиж ирсэн боловч сүүлийн арван жилд улам ч элбэгшин тархжээ. 1913 онд үүссэн “Шинэ толь хэмээх бичиг” сониноос эхлээд өнгөрсөн зууны эхээр монгол хэл дээр гарч байсан хэвлэлүүдэд ч, 20-50-иад оны сонинуудад ч ярилцлага, түүний элементүүд илэрхий ажиглагдаж байжээ. Энэ тухай сэтгүүл зүйн нэрт судлаач доктор Г.Дэлэг өөрийн хоёр боть бүтээлдээ тэмдэглэсэн байна. Яриа ярилцсан нь гэдгээс үүсвэрлэж “яриулах”, “ярилцах” улмаар “ярилцлага авах” гэсэн мэргэжлийн өвөрмөц үг хэллэгүүд үүсч, тэр нь сэтгүүл зүйн практикт ярилцлага

хэмээх төрөл зүйлийг бүтээсэн түүхтэй². Монголчууд бид хууч хөөрөх, хуучлах ч гэж эрт дээр үеэс ярьдаг нь сонины ярилцлагын үүсэл хөгжилтэй холбоотой юм.

Монголын өдөр тутмын сонин, сэтгүүл, цахим хэвлэлээс ажиглахад ярилцлагын зах зээл маш өргөн, эрэлт шаардлагатай байгаа нь илт байна. Эндээс харахад сэтгүүл зүйн бичлэгийн төрлүүдээс мэдээ, ярилцлага гэсэн хоёр зүйл зах зээлийн нийгмийн шинэхэн эрэлт хэрэгцээ болж хувирсан гэж хэлж болно. Үүний тод жишээ бол зах зээлийн өнөө үед алт шиг үнэтэй сонины зай талбайг удирдлага нь огт харамлахгүй ярилцлагад онцгой ач холбогдол өгч, хэдэн ч нүүр дамнан нийтлүүлж, хамгийн их орон зай эзэлж буй явдал юм.

Ярилцлагыг манай сэтгүүл зүй судлаачид янз бүрээр тодорхойлж, талбарласан байдаг. Профессор, доктор М.Зулькафиль: “Ярилцлага гэдэг бол ямар нэг сэдвийн талаар ОНМХ-ийн бүхэл бүтэн нийтлэл, нэвтрүүлгийг бүтээж чадахуйц сэтгүүлч, ярилцагч хоёрын хоорондох тодорхой дэс дарааллыг хадгалсан асуулт хариултын хэлхээ холбоо мөн” гэж тодорхойлсон бол профессор, доктор Л.Норовсүрэн: “Ярилцлага нь уншигчийн анхаарлыг дэлхий дахины болон улс орны хэмжээнд болж байгаа цаг үеийн үйл явдалд зохих үнэлэлт, дүгнэлт өгөх зорилготой” гэж тэмдэглэжээ³. Судлаач, доктор Ч.Чойсамба: “Ярилцлага гэдэг нь ямар нэг тодорхой асуудлаар сэтгүүлч, ярилцагч хоёрын хооронд өрнүүлсэн яриа юм” гэсэн тодорхойлолт өгчээ. Судлаач, доктор Б.Болд-Эрдэнэ: “...Бичлэгийн төрөл

зүйл дотроос ярилцлага нь хамгийн их өөрчлөгдөж шинэчлэгдсэн төдийгүй үр нөлөө, ач холбогдлоороо онцгой мэдээллийн хэлбэр болсон”⁴ гэсэн бол судлаач, доктор Ж.Батбаатар: “Ярилцлага хэмээх ойлголт, нэр томъёог сэтгүүл зүйд хоёр үндсэн утгаар хэрэглэдэг. 1-рт хөрөглөлийн төрөлд хамаарах бичлэгийн тодорхой нэг хэлбэр, 2-рт хүмүүс буюу янз бүрийн түвшний эх сурвалжуудтай ярилцах замаар мэдээлэл олж авах арга хэрэглүүр болдог” гэжээ. Эдгээр тодорхойлолтууд нь ярилцлагыг хэлбэрийн болон ач холбогдол, арга барилын талаас нь тодорхойлсон товч тайлбарууд юм.

Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйлүүдээс сонины ярилцлага нь эх сурвалж, уншигчидтайгаа хамгийн ойр харилцаа үүсгэж илүү амьд бодит хандлагыг бий болгодоогоороо давуу талтай юм. Ярилцлагын эх сурвалж тодорхой байхаас гадна өөрийн үг, өнгө аясаар үзэгч, сонсогч уншигчтай “шууд ярьдаг” тул бичлэгийн бусад төрөл зүйлээс илүү итгэл үнэмшил төрүүлдгээрээ өвөрмөц юм. Ярилцлагыг тодорхой зорилго, чиглэл бүхий асуулт, хариулт солилцох үйл явц хэмээн тодорхойлсон нь түгээмэл байдаг. Өөрөөр хэлбэл ярилцлагад дор хаяж хоёр хүн оролцож, нэг нь асууж, нөгөө нь хариулдаг. Ярилцлагын үйл явц сэтгүүлч болон ярилцлага өгч буй хүнээс шууд хамаардаг. Тиймээс сэтгүүлч, ярилцагч хоёрыг ярилцлагын үндсэн элементийг бүрдүүлэгч гэж үзэж болно. Ярилцлагыг чиглүүлж буй сэтгүүлчээс ярилцлагын агуулга, ерөнхий явц маш их шалтгаалахын зэрэгцээ ярилцагчийн мэдлэг, хувийн

туршлага, шинж чанар бас нөлөөлдөг. Нөгөө талаас сэтгүүлч ярилцлагыг олон нийтэд буюу уншигч, сонсогч, үзэгчдэд зориулдаг. Өөрөөр хэлбэл ярилцлагын гол хүлээн авагч нь олон нийт байдаг учир сэтгүүлчид олон нийт үүнийг сонирхох болов уу? Тэд юу асуухыг хүсэж байгаа бол хэмээн бодож, тэдний өмнөөс сэтгэж, сонирхол, хэрэгцээ шаардлагыг нь хангахыг хичээх хэрэгтэй байдаг. Сэтгүүлч хүн хувийн зүгээс биш, уншигч, үзэгч, сонсогчдын өмнөөс асуулт тавьж, хариулт авдаг.

Манай сонинуудын ихэнх зайг ярилцлага эзэлдэг нь бичих боловсруулахад сэтгүүлчээс нарийн хүч хөдөлмөр шаардахгүй бусад төрлөөс харьцангуй амар хялбар байдагтай холбон үздэг нь өрөөсгөл асуудал юм. Чанаргүй, сэтгүүлчээс нөр их хөдөлмөр шаардаагүй материал уншигчаа хуурч мэхэлнэ гэсэн үг юм. Харин сэтгүүл зүйн аль ч бичвэр байсан бүгд л сэтгүүлчээс нарийн мэдрэмж, хүч хөдөлмөр, ур чадвар шаарддаг. Тухайн сэтгүүлч уншигчдаа хэрхэн үнэлнэ тэр хэмжээндээ л тохируулж бичдэгээс шалтгаалж байгаа юм. Ярилцлагын нэг онцлог бол үйл явдлыг сэтгүүлчийн нэрийн өмнөөс биш, харилцан ярилцагч хүний нэрийн өмнөөс авч үзэх юм. Иймээс ярилцагч хүн гол байр суурь нь байна. Сүүлийн үед Монголын сэтгүүл зүйд ярилцлага олшрох болсон

сайн талтай ч ярилцлагын чанар чансаа сэтгүүлчээс ихээхэн шалтгаалдаг гэдгийг зарим нэг нь дутуу ойлгож байна. Ярилцах сэдэв, үйл явдал, баатрын тухай урьдчилан судалж тавих асуултаа зөв сонгож, яриаг соёлтой хөтөлж явуулах сэтгүүлчдийн үүрэг орхигдсоор байна. Шар мэдээ давамгайлсан өнөөдрийн нийгэмд сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлүүд үндсэн элементээ алдаж, сэтгүүлчид нь ч ёс зүйгүй мэдээ, мэдээлэл, ярилцлагын араас хөтлөгдөн уншигчдыг төөрөгдүүлж, урлагийн, улс төрч, нийгмийн идэвхтэй хүмүүсийн нэр төрд халдах цаашлаад амьдрал ахуйг нь бусниулах бичвэр нийтлэлүүд олширсоор байгаа нь нууц биш билээ. Үүнээс үзэхэд мэргэжлийн сэтгүүлч, сэтгүүл зүйн бичвэрийн төрөл, зүйлийнхээ үндсэн элементүүдийг агуулсан үнэн бодит, уншигчдаа хүндэлсэн нийтлэл бичих нь нэн чухал юм. Тэгэхээр нийгмийг анагаагч, нийгмийг гэгээрүүлэх эсэх эдгээр шийдлүүдийн эрх сэтгүүлчдийн оюун мэдэлд байгаа гэж хэлж болно.

Зарим сонины ашигтай талбайн 50 орчим хувийг ярилцлага эзлэх болжээ. Нэг дугаарт янз бүрийн хэмжээний 5-16 ярилцлага нийтлэгдэх болов. Үүний уршгаар ярилцлагаас залхах сэтгэл зүй уншигчдад үүсээд байна. Проф. М.Зулькафилийн тэмдэглэсэнээр:



*Манай сонинуудын ихэнх зайг
ярилцлага эзэлдэг нь бичих
боловсруулахад сэтгүүлчээс
нарийн хүч хөдөлмөр
шаардахгүй бусад төрлөөс
харьцангуй амар хялбар
байдагтай холбон үздэг нь
өрөөсгөл асуудал юм. Чанаргүй,
сэтгүүлчээс нөр их хөдөлмөр
шаардаагүй материал уншигчаа
хуурч мэхэлнэ гэсэн үг*



“Өнөөдөр ярилцлагын араас хэт хөөцөлдөж, түүнийг сонины нэг дугаарт бөөн бөөнөөр нь нийтлэх явдал газар авч, энэ бичлэгийн төрөл моодонд орох хандлага ажиглагдаж байна. Энэ нь мэдээллийн багтаамжийг сайжруулах, шуурхай чанарыг дээшлүүлэх сайн талтай боловч бүх нийтлэл бичлэгийн нэг хэлбэртэй болж... сонины нийтлэлийн бодлого, гадаад дүр төрх, өнгө үзэмжинд сөрөг нөлөө үзүүлж, редакцийн газрын ажлын үр ашгийг бууруулж болох юм. Гэтэл 20-30 жилийн өмнө манай төвийн томоохон хэвлэлүүдэд ярилцлага нэг дугаарт нэг үзэгдэх үгүйтэй байсан гэхэд одоо итгэмээргүй” гэж бичсэн байна.

Монголын өдөр тутмын сонины ярилцлагын сэдэв, агуулга, хэлбэр, бичих ур чадварт гарч байгаа өөрчлөлт шинэчлэл, түүний үр нөлөөг сэтгүүлчийн ур чадвартай холбон судлах зорилгоор “Өнөөдөр”, “Үндэсний шуудан” сонины 2014 оны 4, 5-р сарын 94 дугаарын 383 ярилцлагад, мөн сэтгүүлч У.Амарсайхан, Д.Хатанбаатар, Б.Ганчимэг нарын ярилцлагуудад дүн шинжилгээ хийхийг оролдлоо. Өдөр тутмын сонинд ярилцлага хэмээх сэтгүүл зүйн бие даасан бичлэгийн зүйл ямар түвшинд бичигдэж, уншигчдад ямар стандарттай хүрч байгааг судлахыг зорьсон. Дээр стандарт гэж тод томруун тусгасаны учир үе үеийн ярилцлагын мастер гэж сэтгүүл зүйн эрдэмтэн судлаачид үнэлж, дүгнэдэг гурван сэтгүүлчийн 9 ярилцлаганд дүн шинжилгээ хийж, түүнийгээ онолын асуудалтай холбон тайлбарлахыг зорилоо.

Судалгааны явцад сонины бичлэгийн төрөл зүйлүүдээс дунджаар нэг дугаарт 5-аас дээш ярилцлага нийтлэгддэг, бусад эх бичвэрийг бэлтгэхэд ярилцлагыг ашигладаг нь ажиглагддаг. Тухайлбал, олны танил хүнтэй хийсэн чөлөөт ярилцлага гэхэд нэг бүтэн нүүр байх нь энгийн үзэгдэл, дээд тал нь гурван нүүр эзэлдэг маш урт ярилцлага ч байна. Уншигчид чанарын шаардлага хангасан ярилцлага хүлээн авч уншиж байна уу гэдэг эргэлзээтэй байсан бол энэхүү судалгааны эцэст мэргэжилтэнтэй хийсэн мэдээлсэн шинжтэй ярилцлага нийт ярилцлагын талаас илүү хувийг, олны танил хүнтэй хийсэн чөлөөт ярилцлага 1/3 хувийг эзэлж байна. Харин жирийн хүнтэй хийсэн ярилцлага, хөрөг ярилцлага тус бүр 2-3%-ийг эзэлжээ. Ярилцлагын сэдвийн хувьд өдөр тутмын сонины онцлог нь цаг үе, улс төр, эдийн засаг, урлаг гэсэн үндсэн 4 сэдэв давамгайлж байгаа бол экологийн тухай ярилцлага тун цөөн нийтлэгджээ. Ярилцлагын хэлбэрийн хувьд нийтлэг нь нүүр тулсан ярилцлага бол нэн ховор тохиолдол нь утсаар авсан ярилцлага, онлайн ярилцлага байна. Харин мэдээлсэн 2-6 асуулттай тодруулга ярилцлагын тоо хэмжээ их байгаа нь ажиглагдсан. Захиалгат ярилцлагын хувьд өдөр тутмын хоёр сонинд бага хувийг эзэлсэн ч зарим ярилцлагыг захиалгат мөн, биш гэж ялгахад хүндрэлтэй байлаа.

Үүнээс үзэхэд өдөр тутмын сонины сэтгүүлчид эхлээд ямар хэлбэрийн, ямар зорилго, агуулгатай ярилцлага хийхээ төдийлөн тодорхойлдоггүй шууд л эх сурвалжтай уулзаж асуулт асуухаа л түрүүнд тавьдаг хандлага

анзаарагдаж байна. Сэтгүүлч асуултаа бэлтгэдэг эсэх нь мөн л адармаатай. Тухайн ярилцлагыг уншихад л бэлтгэсэн асуулт, бэлтгээгүй шууд тавьсан асуулт нь анзаарагдаж байдаг. Мөн дараагийн асуудал бол ярилцлагаа найруулан бичихдээ анхаарах зүйл нь үгийн сонголт, асуултын дэс дараалал, логик холбоос гэх мэт юм. Эдгээрийг анхаарахгүй ярилцлага бэлтгэснээр уншигчид замбараагүй мэдээлэл авах, хэтэрхий нуршуу олон хуудас ярилцлага нийтэлж, уншигчдын чанарын шаардлага хангахгүй байна. Мелвин Менчер “Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс” хэмээх бүтээлдээ “Сайн ярилцлага хийхийн тулд юуны түрүүнд юуг олж мэдэх гэж байгаагаа өөрөө ухамсарлаж байх нь чухал. Ярилцлага хийхдээ дараах зүйлсийг удирдамж болгож болох юм. Мэдээллийн эх сурвалжаас чухам юу олж сонсох гэж байгаа тухай өөрөө тодорхой төсөөлөлтэй байх хэрэгтэй. Мөн гол асуултандаа хурдан ор, ярилцаж байгаа хүнээ маш сайн анзаар, ярилцагчтайгаа уулзахаасаа өмнө бэлтгэлтэй бай, асуулгүй орхигдуулсан зүйл байгаа эсэхээ хянаж үзэх хэрэгтэй”⁵ гэж зөвлөсөн байдаг.

Судалгааны эцэст дүгнэхэд сонины ярилцлага бол зөвхөн асуулт хариулт эвлүүлэн бичих бичвэрийн төрөл биш. Ач холбогдол өгч асуултаа бэлтгэж, эх сурвалжаа судалж, ярилцлагын агуулга хэлбэрээ тодорхойлж зорилгоо биелүүлэхэд чанартай ярилцлагын шалгуур оршино. Өдөр тутмын сонин хэдий цаг хугацаа давчуу ч гэлээ ямар ч сэтгүүлч уншигчаа хуурах эрхгүй билээ. Тийм учир мэргэжлийн сэтгүүл зүйн шаардлага хангасан чанартай ярилцлагыг

уншигч олонд хүргэх нь мэргэжлийн хариуцлага юм.

Ярилцлагаар дагнасан сэтгүүлчид олширсон хэдий ч судлаачид Монголын сэтгүүл зүйд гайхалтай содон ярилцлага хийж, онцгойрч тодорсон нь тун цөөхөн гэж үздэг. Хэрэв ярилцлага хэмээх бичлэгийн зүйлийн боломжийг гүйцэд ашиглаж чадвал энэ нь ихээхэн ирээдүйтэй нь тодорхой.

Сэтгүүл зүйн ярилцлагын ур чадварыг миний бие зарим сэтгүүлчийн бүтээлүүд, тухайлбал МСХ-ны шагналт сэтгүүлч У.Амарсайханы “Амьд сэрүүнд нь хайрлаж халамжлахсан”, Д.Хатанбаатарын “Өөр оршихуй-1”, Б.Ганчимэгийн “Ярилцъя” бүтээлээс сонгосон ярилцлагууд дээр хийсэн ажиглалтаараа батлан өгүүлэх болно. Ер нь ерэн оноос хойш У.Амарсайхан, Нанж. Лхагва, Д.Хатанбаатар, Б.Ганчимэг нараас өөр ярилцлагын төрлөөр дагнан бие дааж ном гаргасан хүн ховор юм. Сонины ярилцлагын гол төлөөлөгч гурван сэтгүүлчийн 8 ярилцлаганд дүн шинжилгээ хийснээр ярилцлагын арга барил, сэтгүүлчийн уран чадвар, ярилцлагын чанарт хэрхэн нөлөөлдөг болохыг батлахыг зорьсон юм. Дээр дурдсан сэтгүүлчид өөрсдийн гэсэн арга барил, тактикаар ярилцлагаа бүтээжээ. У.Амарсайхан сэтгүүлчийн хувьд 1960-1970-аад оны үед ярилцлагаа голлон нийтэлж байв. Тэр үеийн урлагийн хүмүүстэй хийсэн ярилцлагуудаа эмхэтгэн “Амьд сэрүүнд нь хайрлаж халамжлахсан” бүтээлээ 1994 онд хэвлүүлжээ. Тэр үеийн ахмад уран бүтээлчид, урлагийн гавьяатнуудын хөрөг ярилцлагыг бүтээхдээ маш чадварлаг ажилласан нь дээрх

бүтээлээс анзаарагдсан. Түүний ярилцлага хийх арга барил нь товч асуулт тавьж их зүйл яриулдаг, мөн тухайн ярилцагчийг өөрөөр нь өөрийг нь бүтээлгэдэг онцлогтой бөгөөд ихэнх ярилцлага нь 10-18 асуултаас бүрджээ. Тухайн цаг үед сонины зай талбай хомс ер нь бага хэмжээ ноогдог байсан нь ажиглагдсан. Урлагийнхантай хийсэн ярилцлагад мэдрэмжийн асуулт түлхүү байгаагаас гадна уншигчдыг зугаацуулах цэнгүүлэх үүргээ сайн гүйцэтгэжээ.

Д. Хатанбатаар сэтгүүлчийн ярилцлага нь 1970-1980-аад оны үед “Залуучуудын үнэн” сонинд голлон нийтлэгджээ. Тэрээр тухайн үеийн ярилцлагуудаа “Өөр оршихуй-1” бүтээлдээ эмхэтгэсэн байна. Түүний ярилцлагын ихэнх эх сурвалж нь мөн л урлагийн хүмүүс юм. Тэрээр ярилцагчийнхаа мэргэжлийн онцлогийг заавал яриулдаг, уншигчдад зөвлөгөө өгөх аргаар хэрхэн амжилтанд хүрсэн тухай дурсамжуудыг яриулж залуу уншигчдад үлгэх дуурайлал болох үр дүнтэй ярилцлага хийдгээрээ онцлог юм. Түүний ярилцлагууд нь харьцангуй олон асуулттай, дунджаар 8-22 асуулттай байх жишээтэй. Уг сэтгүүлчийн хувьд найруулан бичих чадвар маш сайн бөгөөд үг сонголт, найруулга, асуултын логик дараалалд онцгой анхаардаг байна.

Сэтгүүлч Б.Ганчимэг харьцангуй залуу үеийн төлөөлөгч юм. Энэ нь түүний ярилцлагын агуулга, чанарт нөлөөлдөг нь ажиглагдсан. Учир нь залуу хүний овжин, сэргэлэн зан чанар ярилцлагыг нь уншихад шууд мэдрэгддэг. Зарим тохиолдолд хэтэрхий хамжааргагүй, эрээ цээргүй мэт боловч

үүнд тухайн цаг үе мөн нөлөөлж байгаа гэж хэлж болно. Сэтгүүлчийн ур чадварт Барууны сэтгүүл зүйн арга барил, өнгө аяс тодорхой хэмжээгээр ажиглагдсан. Жишээ нь: хэтэрхий задгай, чөлөөтэй, нөгөө талаасаа замбараагүй гэж хэлж болно. Шинэлэг өнгө аяс бүрдүүлж асуултын дэг, агуултын хувьд тэс ондоо гарч ирснээрээ онцлог юм. Зарим тохиолдолд ярилцагчдаа хэтэрхий чөлөөтэй ханддаг. Нуршуу асуулт их, өдөөн хатгасан дайрч давшилсан асуултаар ярилцлагаа эхэлдэг гэх мэт шинэлэг хандлагууд нь түүний ур чадварын онцлог юм. Энэ бүхнийг дүгнэж хэлэхэд:

1. Ярилцлага нь өдөр тутмын сонинд өргөн хэрэглэгддэг сэтгүүл зүйн бичлэгийн нэгэн чухал зүйл юм. Мөн сэтгүүл зүйн бүх бичлэгийн төрлийн үндсэн нэг элемент буюу чанартай ярилцлага нь ямар ч бичвэрийн эх сурвалж, цаашлаад гол тулгуур зүйл болно. Сэтгүүл зүйн ихэнх бичвэрт ярилцлага хэрэглэгддэг.

2. Сэтгүүлчийн ур чадвар нь чанартай ярилцлагын үндсэн нэг шалгуур болдог. Сэтгүүлч өөрөө бүтээгч, судлаач, шинжээч байж эх сурвалжаа тодорхойлж, асуултаа урьдчилж сайн боловсруулсан, өөрийн гэсэн өнгө аяс, тактикийн бичлэгийн ур чадвар, хэл найруулга сайн, нарийн мэдрэмжтэй, ёс зүйтэй, мэргэжлийн хариуцлагатай ажилласан ярилцлага ямагт үр өгөөжтэй, нөлөөлөх чадвар сайтай байдаг нь ажиглагдлаа.

3. Сонины ярилцлагад нийгэм, цаг үе, ярилцагчийн мэдлэг боловсрол, байр суурь, мэргэжил, сэтгүүлчийн ур чадвар, редакцын бодлого, уншигчдын

хүсэлт, эрэлт хэрэгцээ, хандлага зэрэг хүчин зүйл нөлөөлдөг.

4. Ярилцлагын бичлэгийн ур чадвар, мэдээллийн багтаамжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулж, тооноос хэлбэрээс чанарт шилжих шаардлага тулгарч байна. Ярилцагчаа зөв сонгох, олны танил хүмүүсээс аль болох татгалзаж, иргэний төлөөллөөс сонгож, сэдвийн хүрээг өргөжүүлэх шаардлагатай юм.

Ишлэл

¹ Зулькафиль М. 2009. Сэтгүүлчийн ур чадвар. УБ., х. 67.

² Баасансүрэн Т. 2000. Сэтгүүлчийн уран чадварын тухай яриа. УБ., х. 26.

³ Зулькафиль М., Норовсүрэн Л. 2002. Ярилцлага. УБ., х. 15.

⁴ Чойсамба Ч. 2001. Сонины мэдээллийн бичлэгийн төрөл зүйл. УБ., х. 21.

⁵ Менчер М. 2005. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс. УБ., х. 235.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Амарсайхан У. 1994. Амьд сэрүүнд нь хайрлаж халамжлахсан. УБ.

2. Баасансүрэн Т. 2002. Сэтгүүлчийн уран чадварын асуудал: уламжлал ба шинэчлэл. УБ.

3. Батбаатар Ж. 2007. Сэтгүүл зүй. УБ.

5. Ганчимэг Б. 2000. Ярилцъя. УБ.

6. Дэлэг Г. 1972. Монголын хэвлэл. УБ.

7. Зулькафиль М. 2013. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ.

8. Зулькафиль М. 2009, 2012. Сэтгүүлчийн уран чадвар-1, 2, 3. УБ.

9. Менчер М. 2002. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ.

10. Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйл. УБ.

11. 2012. Радио сэтгүүлчийн гарын авлага. Дойче Велле Академи. УБ.

12. Харольд У.Андерсен нар. 2008. Нийтлэл, нэвтрүүлгийг яаж бэлтгэх вэ?, УБ.

13. Хатанбаатар Д. 2013. Өөр оршихуй-1. УБ.

14. Чойсамба Ч. 2011. Сонины мэдээллийн бичлэгийн төрөл. УБ.

Abstract

The demand of informational interview is getting higher and wider in coverage of Mongolian daily newspapers, magazines and digital media outlets. The news and interview has become major journalism genres in Mongolian journalism. However, newspaper managers and directors allow publishing interviews on every pages of their newspaper, which is valuable space, without any hesitation and esteem the importance of interview in modern media marketing. Although, it can be wrong saying that publishing interview on a newspaper is easier than advocating particular viewpoints or influencing audience opinions, the most spaces of newspaper is filled with interview. The interview is one of the most common genres of journalism which is used for daily newspapers and other media outlets in Mongolia. The main factor of qualified interview is well-trained, skillful professional journalists.